



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, 61.1.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/1205 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрмийн 7.1.1 дэх заалт, Газрын даргын 2019 оны А/143 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 11,12 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Газрын "Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийн хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (С.Оюунцэцэг)-т үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөнд тусгагдсан ажилд шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (З.Отгонбат)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Анар)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЭНХТАЙВАН

1150501014



Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр А. О. БАЯАР тушаалын хавсралт

502400864
6564225 5-01517735

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023 оны 01 дүгээр сарын 12

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх ажил	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Төсөв (мян.төг)
1	2	3	4	5	6
1.	Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх	НЭГ. АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШҮҮЛЭХ 1.Журамд заасан богино болон дунд хугацааны сургалт, мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдыг хамруулах. 2.Албан хаагчийг чадавхжуулах сургалтад хамруулах. 3.Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын сургалтад хамруулах, зохион байгуулах. 4.Албан хаагчдыг бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, суралцах бололцоогоор хангах. (докторант, магистрт сурах)	Чанар: Төрийн албаны сургууь, НЗДТГ-ын сургалтын төвөөс зохион байгуулсан сургалтад хамруулах. Гэрчилгээ авсан албан хаагчийн тоо. Чанар: Төлөвлөгөөний дагуу сургалтад хамруулсан байна. Сургалтын тоо, хамрагдсан албан хаагчийн тоо. Чанар: Зохион байгуулсан хууль, тогтоомж, дүрэм журмын сургалтын тоо, хамрагдсан албан хаагчийн тоо. Чанар: Суралцах бололцоогоор хангагдсан албан хаагчийн тоо.	Хууль, журамд заасан шаардлагыг хангасан албан хаагчдыг хамруулж мэргэшүүлсэн байх. Сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлон, албан хаагчдын чадавхыг дээшлүүлсэн байх. Хууль, журмыг мөрдөн зөрчилгүй ажилласан байх. Доктор, магистрын боловсролын тухайн жилийн хөтөлбөрийг дүүргэсэн байх.	- - -
ХОЁР. АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, ТААТАЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ					

1	2	3	4	5	6
2.	Албан хаагчдын ажиллах таатай орчинг бүрдүүлэх	1. Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээг өдөр бүр тогтмол хийлгэх, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх. 2. Компьютер, хэвлэгч, скайнер, суурин утас бусад шаардлагатай техник хэрэгслээр хангах, цахим сүлжээнд бүрэн холбох, албан ажлын хэрэгцээнд шаардлагатай програмуудыг суулгах. 3. Галын болон болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх.	Чанар: Албан хаагчдын ажиллах цэвэр, эрүүл, аюул орчныг бүрдүүлсэн талаар судалгааны тоо болон чанар. Чанар: Ажиллах таатай орчныг бүрдүүлэн шаардлагатай тоног, төхөөрөмж, техник хэрэгслээр хангасан тоо, чанар	Эрүүл ахуйн шаардлага хангасан, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлсэн байх.	4,350.0
Гурав. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах, тэтгэмж тэтгэлэгт хамруулах					
3.	Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажил зохион байгуулах.	1. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль эрх зүйн актууд, Газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасан тэтгэмж, тусламжуудыг олгож дэмжлэг үзүүлэх. 2. Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах. 3. Хүүхдийн баяр, Шинэ жилийн баярыг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдэд баяр хүргэх.	Чанар: Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, дүн.	Төрийн албаны тухай хуулийн дагуу албан хаагчийн нийгмийн баталгааг хангах.	10,000.0

1	2	3	4	5	6
		4. Байгууллагаас насны тэтгэвэрт ахмад настнуудыг авах ажлыг зохион байгуулах.	Чанар: Хүндэтгэл үзүүлсэн арга хэмжээ, ахмадын тоо, дүн.	Ахмадын баяр, Сар шинийн баярыг тохиолдуулан ахмад настнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн байх.	6
ДӨРӨВ. АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИН ХӨЛС, УРАМШУУЛЛЫГ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ, ШАГНАЖ УРАМШУУЛАХ					
4.	Албан хаагчдын цалин хөлсний нэмэгдэл, урамшуулах, шагнаж ажлыг зохион байгуулах	1.Хууль, тогтоомжийн дагуу албан хаагчдын цалин хөлс, зэрэг, дэвийн нэмэгдлийг шинэчлэн тогтоох 2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг журамд заасан хугацаанд үнэлэх ажлыг зохион байгуулах, үнэлгээнд үндэслэн арга хэмжээг авах 3.Ажлын үр дүнгээр албан хаагчдыг шагнаж, урамшуулах ажлыг зохион байгуулах	Чанар: Цалингийн шатлал, зэрэг, дэв, түүний нэмэгдлийг нэмэгдүүлсэн болон шинээр олгосон албан хаагчийн тоо. Чанар: Үнэлгээнд суурилж авсан арга хэмжээний тоо, үнэлүүлсэн албан хаагчийн тоо, дүн	Цалин хөлс, зэрэг дэвийн нэмэгдлийг хууль, журамд нийцүүлэн нэмэгдүүлж ажилласан байх. Үнэлгээг үнэн зөв, бодитой хийж, үнэлгээнд нийцсэн арга хэмжээг авч ажилласан байх.	920,047.4
ТАВ. АЖЛЫН БАЙРАНД АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ					
5.	Албан тушаалд албан хаагч сонгон шалгаруулах	1.Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх	Чанар: Сул орон тоог нөхөхөөр авсан арга хэмжээний тоо, нөхсөн байдал.	Төрийн албаны тухай хууль, Албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагад нийцсэн иргэнийг сонгон шалгаруулан томилгох.	
ЗУРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ ШИНЭЧЛЭН БАЯЖУУЛАХ					
6.	Хүний нөөцийн нэгдсэн бүрэлдэхүүн удирдлагын системд хөдөлгөөнийг шинэчлэх	1. Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системд бүрэлдэхүүн хөдөлгөөн, албан хаагчтай холбоотой мэдээллийг тухай бүр шинэчлэх.	Чанар: Системд бүрэлдэхүүн хөдөлгөөн, албан хаагчтай холбоотой мэдээллийг оруулсан байдал, тоо.	Хүний нөөцийн удирдлагын системийг үнэн зөв хөтөлж, шинэчлэлийг бүрэн хийсэн байх.	

1	2	3	4	5	6		
ДОЛОО. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЭРСДЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАХ							
7.	Хүний нөөцийг эрсдлийн удирдлагаар хангах	1. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг албан хаагчдад таниуулах 2. Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах бүрдүүлэх.	Чанар: Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал. Чанар: Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар авсан арга хэмжээ.	Төлөвлөгөөтэй танилцаж хэрэгжилттэд хяналт тавих.	-		
НАЙМ. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ							
8.	Байгууллагын соёлыг хөгжүүлэх	1. Байгууллагын соёлыг хөгжүүлэх, бэхжүүлэх үүднээс урлаг, спортын олон талт арга хэмжээг зохион байгуулах.	Чанар: Урлаг, спортын арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан, зохион байгуулсан арга хэмжээ, зарцуулсан дүн.	Хамт олныг идэвх санаачлагатай, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд анхаарч ажиллах.	-		
ЕС. ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ БҮРДҮҮЛЭХ							
9.	Хүний нөөцийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангах	1. Сул орон тооны зарыг ил тод мэдээлэх 2. Хүний нөөцийн хөтөлбөр түүний хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг ил тод мэдээлэх. 3. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, зөрчлийн мэдээг ил тод мэдээлэх	Чанар: Сул орон тооны мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод хүргэсэн байдал, тоо Чанар: 2023 оны төлөвлөгөө болон түүний биелэлтийг хагас, бүтэн жилээр цахим хуудаст байршуулж мэдээлсэн байна. Чанар: Аливаа ёс, зүйн зөрчилгүй ажилласан байна. Мэдээллийг цахим хуудас байршуулсан байна.	Сул орон тооны мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод хүргэсэн байх. Хүний нөөцийн хөтөлбөр, төлөвлөгөөний тогтоол, хэрэгжилтийг шийдвэрт заасан хугацаанд нэгтгэж ил тод мэдээлсэн байх Ёс зүйн дүрэм, зөрчлийг цахим хуудасд байршуулах.	-		
<table border="0" style="width: 100%;"> <tr> <td style="width: 80%;">Нийт</td> <td style="text-align: right;">934,397.4</td> </tr> </table>						Нийт	934,397.4
Нийт	934,397.4						